



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/204

Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Сайнцагаан сумын Дэлгэрэх бүрд, Хөөт булаг ХХК-ны супермаркет, Баянжаргалан сумын Баян бүрдийн хишиг хоршооны хүнсний дэлгүүрт архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, Сайнцагаан Молор-Од шоп ХХК-ны худалдаа үйлчилгээний газарт архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх, Мөнхийн замбага ХХК-ны паб-д спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 6 дугаар сарын 07-ны өдрөөс 2023 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

2. Сайнцагаан сумын татварын албанд бүртгэлтэй Цоглог ертөнц ХХК-ны супермаркетын тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс хүчингүй болгосугай.

3. Дэлгэрэх бүрд, Хөөт булаг, Молор-Од шоп ХХК-ны худалдаа үйлчилгээний Мөнхийн замбага ХХК-ны худалдаа үйлчилгээний газрын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 08⁰⁰ -24⁰⁰, Баян бүрдийн хишиг ХХК-ны худалдааны газрын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг 09⁰⁰-21⁰⁰ цаг хүртэлх хугацаагаар тус тус баталсугай.

4. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210595